



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 26/03

Улаанбаатар хот

Багахангай “Гэрэлтүүлэг, ногоон байгууламж”
орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын бүтэц орон тоо,
цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.4, 52.1.12, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоог нэгдүгээр, цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Багахангай “Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захиралтай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3.Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан шинэчлэн тогтоосон цалингийн хэмжээг 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Багахангай “Гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ (Ч.Батхуяг)-т үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн хороонд тус тус даалгасугай.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоо цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/18 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ